



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Айраг сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2023/07/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий	
	Утас: 70522734	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
	Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
Ахлах аудитор:		Т.Мөнхтогтох
		Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Аудитын санал дүгнэлт



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2022.01.31

№

4-6/29

танай _____ -ны № _____ -т

АЙРАГ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Н.ГАНТУЯА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Айраг сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Айраг сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн дансанд материаллаг хэмжээний өөрчлөлт орсон бөгөөд тодруулбал төсвийн хөрөнгөөр 20.3 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн болон дахин үнэлгээгээр 670.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгөөр нэмэгдсэн байна. Холбогдох шийдвэрээр 56.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, 93.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Төсвийн хөрөнгөөр албан хаагчдад 0.2 сая төгрөгийн гар утасны зардал олгосон, 0.6 сая төгрөгийн сонин захиалсан, 0.8 сая төгрөгийн мөнгөн аяга худалдан авсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 "гар утасны зардал", 12.1.3 "хэвлэлийн захиалгын төлбөр", 15 дугаар зүйлийн 15.1.5 "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"-ыг хориглоно гэж заасантай нийцэхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй байна.

010070301

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/мянган төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	135,483.0	155,617.6
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,324,818.4	3,603,929.5
	Нийт хөрөнгийн дүн	3,460,301.4	3,759,547.1
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,460,301.4	3,759,547.1
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,460,301.4	3,759,547.1
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,181,338.9	1,203,075.5
	Үйл ажиллагааны зардлын дүн	683,398.1	799,824.2
	Үйл ажиллагааны үр дүн	497,940.9	403,251.3
	Үйл ажиллагааны бус үр дүн	-1,236.9	-104,005.5
	Үйл ажиллагааны нийт үр дүн	496,704.0	299,245.8
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	429,469.4	495,510.8
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	418,978.4	475,120.8
	Үйл ажиллагааны ЦМГ	10,491.0	20,390.0
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-10,491.0	-20,390.0
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-
	Тайлант оны үр дүн	-	299,245.8
	Эцсийн үлдэгдэл	3,460,301.4	3,759,547.2
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	377,486.1	445,909.8
	Урсгал зардал	377,486.1	445,909.8
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	377,486.1	445,909.8
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	370,954.5	437,645.3
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	6,531.6	8,264.5

Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулинд дараах чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнд:

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах;
- Засаг даргын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах;
- Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах;
- Хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох;

- Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;
- Төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;
- Тухайн шатны Хурлын хэвийн үйл ажиллагааг ханган үйлчлэх.

Айраг сумын Засаг даргын Тамгын газар нь зорилгоо дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн үйлчилгээг хуульд нийцүүлэн ил тод хөнгөн шуурхай явуулахын зэрэгцээ нутаг дэвсгэрийн зохистой байршил, байгалийн нөөц баялаг, дэд бүтцийн давуу талд тулгуурлан сумаа нийгэм эдийн засгийн бие даан хөгжих нөхцөлийг бүрдүүлэн ажиллах.

Байгууллагын 2022 онд дэвшүүлсэн зорилт:

- Хүүхэд хөгжлийг дэмжих жил

Дөрөв. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн дансанд материаллаг хэмжээний өөрчлөлт орсон бөгөөд тодруулбал төсвийн хөрөнгөөр 20.3 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн болон дахин үнэлгээгээр 670.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгөөр нэмэгдсэн байна. Холбогдох шийдвэрээр 56.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, 93.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлсэн байна.

Тав. Аудитын гол асуудал

Төсвийн хөрөнгөөр албан хаагчдад 0.2 сая төгрөгийн гар утасны зардал олгосон, 0.6 сая төгрөгийн сонин захиалсан, 0.8 сая төгрөгийн мөнгөн аяга худалдан авсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 "гар утасны зардал", 12.1.3 "хэвлэлийн захиалгын төлбөр", 15 дугаар зүйлийн 15.1.5 "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"-ыг хориглоно гэж заасантай нийцэхгүй байна.

Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс хугацаандаа оруулсан 159 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна. Хөрөнгө зарцуулах 83.7 сая төгрөгийн 58 тушаалаас 11.8 сая төгрөгийн 8 тушаалыг байршуулаагүй байна.

Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл 23.1 сая төгрөг бөгөөд дараагийн аудитаар орлого, зарлагын зарцуулалтыг үзэх шаардлагатай.

Найм. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 94.4 сая төгрөгийн 2 алдаа илэрснээс аудитын явцад 94.4 сая төгрөгийн 2 алдааг залруулсан. Үүнд:

1. Цалингийн зардлаас 0.5 сая төгрөгийг бараа материалын зардалд буруу бүртгэснийг залруулав.
2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 07/04 дүгээр тогтоолоор балансаас балансад шилжүүлэх 93.9 сая төгрөгийн, 2 ширхэг хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Аудитаар нийт 1.5 сая төгрөгийн 1 зөрчил илрүүлж, зөвлөмж өгсөн.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төсвийн хөрөнгөөр албан хаагчдад 0.1 сая төгрөгийн гар утасны зардал олгосон, 0.6 сая төгрөгийн сонин захиалсан, 0.8 сая төгрөгийн мөнгөн аяга худалдан авч нийт 1.5 сая төгрөгийг зарцуулсан байгаа нь хууль тогтоомжийн хэрэгжилт бүрэн хангагдахгүй, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэл үүсэх үр дагавартай бөгөөд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 "гар утасны зардал", 12.1.3 "хэвлэлийн захиалгын төлбөр", 15 дугаар зүйлийн 15.1.5 "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"-ыг хориглоно гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

8.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

Д/д	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалтай	Сөрөг	Дүгнэлт өгхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	1	1			1			
	Нийт	1	1			1			

8.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зардалд буруу бүртгэсэн	1	508.8	-	-	1	508.8	1	508.8	-	-	-	-
Балансаас балансад шилжүүлсэн хөрөнгийг бүртгээгүй	1	93,897.6	1	93,897.6	-	-	1	93,897.6	-	-	-	-
Дүн	2	94,406.4	1	93,897.6	1	508.8	2	94,406.4	-	-	-	-

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллаагүй	1	1,523.8	-	-	-	-	1	1,523.8	-	-
Дүн	1	1,523.8	-	-	-	-	1	1,523.8	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-